



**“АВТО ЗАМЫН САЛБАР ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 94 ЖИЛ”,  
“МОНГОЛЫН АВТО ЗАМЧДЫН ХОЛБОО  
БАЙГУУЛАГДСАНЫ 15 ЖИЛ”- ИЙН ОЙН НЭРЭМЖИТ  
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

### **Нэг. Ерөнхий зүйл**

Энэхүү тэмцээний зорилго нь “Авто замын салбар үүсэж хөгжсөний түүхт 94 жил” -ийн ойг тохиолдуулан авто замын салбарын ажилтнуудын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, шилдэг баг, тамирчдыг шалгаруулахад оршино.

### **Хоёр. Тэмцээний төрлүүд**

Тэмцээнийг дараах төрлүүдээр зохион байгуулна. Үүнд:

1. Сагсан бөмбөг (эрэгтэй баг, эмэгтэй баг)
2. Гар бөмбөг (эрэгтэй баг, эмэгтэй баг)
3. Ширээний теннис (эрэгтэй, эмэгтэй)
4. Шатар (эрэгтэй, эмэгтэй)
5. Дартс (эрэгтэй, эмэгтэй)

### **Гурав. Тэмцээн явагдах хугацаа**

Биеийн тамир, спортын тэмцээн **2023** оны **11-р** сарын **23-24** өдрүүдийн хооронд болно. Тэмцээний нээлтийн үйл ажиллагаа **2023** оны **11-р** сарын **23-ны** 08:00 цагт “Буянт Ухаа спортын ордонд”-д болно. Нээлт хаалтын ажиллагаанд бүх тамирчид тухайн байгууллагынхаа нэр лого бүхий жигд хувцастайгаар жагсана. Нээлтэнд байгууллагууд өөрийн компаний нэр лого бүхий 90см х 50см хэмжээтэй самбар, байгууллагын тугийг бэлдэж жагсана.

#### **1. Гар бөмбөг**

Тэмцээн **2023** оны **11-р** сарын **23-ны** өдрийн **08:30** “Буянт Ухаа спортын ордонд”-д эхэлнэ.

#### **2.Дартс**

Тэмцээн **2023** оны **11-р** сарын **24-ны** өдрийн **09:00** цагаас “Буянт Ухаа спортын ордонд”-д эхэлнэ.

Дартсын тэмцээн эрэгтэй, эмэгтэй гэсэн төрлүүдээр явагдана.

Тэмцээн эхлэхийн өмнө тэмцээний нарийвчилсан дүрмийг танилцуулна.

#### **3.Ширээний теннис**

Тэмцээн **2023** оны **11-р сарын 23-ны өдрийн 09:00** цагаас “Буянт Ухаа спортын ордон”-д эхэлнэ.

Ширээний теннисний тэмцээн эрэгтэй, эмэгтэй гэсэн төрлүүдээр явагдана.

Тэмцээн эхлэхийн өмнө тэмцээний нарийвчилсан дүрмийг танилцуулна.

#### **4.Шатрын тэмцээн**

Тэмцээн **2023** оны **11-р сарын 24-ны өдрийн 09:00** цагаас “Буянт Ухаа спортын ордонд”-д эхлэнэ.

Шатрын тэмцээн тэмцээн эрэгтэй, эмэгтэй гэсэн төрлүүдээр явагдана.

Тэмцээн эхлэхийн өмнө тэмцээний нарийвчилсан дүрмийг танилцуулна.

#### **5. Сагсан бөмбөг**

Тэмцээн **2023** оны **11-р сарын 23-ны өдрийн 08:30** цагаас “Буянт Ухаа спортын ордон”-д эхэлнэ.

#### **Тэмцээний хаалтын ажиллагаа**

**2023** оны **11-р сарын 24-ны 19.00** цагт “Буянт Ухаа спортын ордонд”-д болно.

#### **Дөрөв: Тэмцээний хураамж**

1. Сагсан бөмбөгийн эрэгтэй төрөлд оролцох байгууллага 350.000 төгрөг
2. Сагсан бөмбөгийн эмэгтэй төрөлд оролцох байгууллага 350.000 төгрөг
3. Гар бөмбөгийн эрэгтэй төрөлд оролцох байгууллага 350.000 төгрөг
4. Гар бөмбөгийн эмэгтэй төрөлд оролцох байгууллага 350.000 төгрөг
5. Ширээний теннисний төрөлд оролцох нэг хүн 30.000 төгрөг
6. Шатрын төрөлд оролцох нэг хүн 30.000 төгрөг
7. Дартсын төрөлд оролцох нэг хүн 30.000 төгрөг

Баг, тамирчдын тэмцээнд оролцох хураамжийг 2023 оны 11-р сарын 17-ны 14:00 цагаас өмнө Монголын Авто Замчдын Холбооны Хаан банкны 5029541678 дансанд хийх буюу бэлнээр төлсөн байх шаардлагатай.

Тэмцээнд оролцох баг, тамирчдын албан ёсны мэдүүлэг /овог, нэр, албан тушаал, хувийн дугаар заавал бичсэн/-ийг техникийн зөвлөлийн хуралдаанаас өмнө МАЗХ-нд хүргүүлсэн байна.

*Тэмцээнд оролцох баг, тамирчдын албан ёсны мэдүүлэгийг 2023 оны 11-р сарын 17-ны 14:00 цагаас өмнө ирүүлсэн байх шаардлагатай бөгөөд үүнээс хойш мэдүүлэг хүлээн авахгүй болно.*

#### **Тав: Тэмцээнд оролцогчдод тавигдах шаардлага.**

Тэмцээнд оролцогч тамирчин бүр нийгмийн даатгалын шимтгэл нь даатгуулагчийн 01 төрлөөр буюу үндсэн ажилтанаар 6 сар төлөгдсөн байх ёстой бөгөөд дараах баримт бичгийг заавал авчирна. Үүнд:

- ТҮЦ машинаас хурууны хээгээр авсан лавлагаа

*/01 төрлөөс бусад төрөлөөр НДШ төлсөн төлөлтийг тооцохгүй/*

Багийн бүрэлдэхүүнд үндэсний болон олон улсын лигт тоглодог мэргэжлийн тамирчин оролцуулахыг хориглоно.

Тэмцээнд оролцогч тамирчид биеийн байцаалт, ажлын үнэмлэх, нийгмийн даатгалын лавлагааг тэмцээний туршид биедээ авч явах бөгөөд тэмцээний зохион байгуулагчийн тавьсан шаардлагын дагуу тухай бүрд нь шалгуулах үүрэгтэй

Баг, тамирчдын мэдүүлэгт бичсэн нэр, хувийн дугаар зөрөх, компанийн үндсэн ажилтнаас өөр хүн тэмцээнд оролцуулсан, мэргэжлийн тамирчин талбай дээр гарсан маргаантай асуудлыг ерөнхий шүүгч шийдвэрлэх ба тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тухайн багийг тэмцээнээс шууд хасна.

### **Зургаа. Техникийн зөвлөгөөн**

Тэмцээний техникийн зөвлөлийн хурал 2023 оны 11-р сарын 17-ний өдрийн 14.00 цагт МАЗХ-ны сургалтын танхимд /ХУД, 19-р хороолол, Чингисийн өргөн чөлөө гудамж, Билэгт зам ХХК байр. 2 давхар 206 тоот өрөөнд/ болно.

Техникийн зөвлөлийн хуралдаан дээр тэмцээний нарийвчилсан дүрмийг танилцуулж тэмцээний төрлүүдийн хэсэг бүрийн тоглолтын хуваарийг сугалааны журмаар хийнэ.

Тэмцээнд 2 хүртэлх байгууллага хамтарч 1 баг болон оролцож болно.

### **Долоо. Бусад**

Баг, тамирчид хувийн дугаар бүхий шаардлага хангасан тоглолтын хувцастай байна.

Тэмцээн эхлэх цагийг хатуу баримтлах бөгөөд тоглолт эхлэх цаг зарласнаас 5 минут хоцорсон тохиолдолд хожигдсоноор тооцно.

Тэмцээний явцад гарсан маргаантай асуудлыг тухай бүрд нь техникийн комисс болон ерөнхий шүүгч шийдвэрлэнэ.

“Буянт Ухаа спортын ордонд”-д хувцас солих 3 өрөөтэй бөгөөд тоглолтонд оролцох баг тамирчид тухай бүрд нь ашиглах ба нийт тамирчид өөрийн солих хувцас, эд зүйлээ өөрөө хариуцна. Гээсэн, алдагдсан эд зүйлийг зохион байгуулах комисс болон “Буянт Ухаа спортын ордонд” хариуцахгүй болохыг анхааруулж байна.